

## МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.3, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 244 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”, Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн 8-р зүйлийн 8.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 сарын 12-ны өдрийн 11:00 цагт Блю Скай Зочид Буудлын Кристал хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
  - 2.1. Компанийн шинэчилсэн дүрмийг батлах;
  - 2.2. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус шинэ гишүүдийг томилох;
  - 2.3. Компанийн хувьцааг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааны хэрэгжилт, үр дүн болон уг ажиллагаатай холбогдон гарсан зардлын тайланг танилцуулах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийг 2018 оны 11 сарын 20-ны өдрөөр тасалбар болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр хийлгэсүгэй.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг энэхүү тогтоолын **Хавсралт №1**-ээр баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2018 оны 10 сарын 31-ны өдөр, 2018 оны 11 сарын 14-ны өдрүүдэд өдөр тутмын сонин болон Компанийн [www.mandal.mn](http://www.mandal.mn) болон, Монголын Хөрөнгийн Биржийн [www.mse.mn](http://www.mse.mn) цахим хуудсаар тус тус дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой, хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарах шийдвэрийн төслийг энэхүү тогтоолын **Хавсралт №2**-оор баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг **Хавсралт №3**-аар баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2018 оны 12-р сарын 12-ны өдрийн 11 цаг 00 минут хүртэл байна.
7. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2018 оны 10-р сарын 31-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын Хавсралт №1 болон Хавсралт №2 дахь мэдээлэл болон Компанийн тухай хуулийн 80.11-т заасан мэдээллийн хамт тус тус хоёр хувь үйлдэж хүргүүлсүгэй.